



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.03.30

№ ХЭ2014001

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлангийн тухай**

Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 3 сарын 30-ны өдрийн ээлжит хуралдааны санал хураалтын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.9 заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Компанийн 2013 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэлтэйд тооцон, зөв гэж үзсүгэй.

ХОЁР. Компанийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  С.БАЯНЧУЛУУН





“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.03.30

№ ХЭ2014002

Улаанбаатар хот

ТУЗ-ийн 2013 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 3 сарын 30-ны өдрийн ээлжит хуралдааны санал хураалтын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.15 дахь заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. ТУЗ-ийн гишүүдийн 2013 оны үйл ажиллагааны тайланг үндэслэлтэйд тооцон, зөв гэж үзсүгэй.

ХОЁР. ТУЗ-ийн 2013 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  С.БАЯНЧУЛУУН





“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.03.30

№ ХЭ2014003

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг сунгах тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 3 сарын 30-ны өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 77.1; Компанийн дүрмийн 7.7.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхийн саналыг авсан нэр бүхий 7 гишүүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурал хуралдах хүртэл хугацаагаар сунгасугай.

ТУЗ-ийн ердийн гишүүн

Сандагийн Балжинням
Сандагийн Баянчулуун
Сандагийн Баянмөнх
Маамуугийн Нямдаваа
Цэндсүрэнгийн Ганцэцэг
Норовын Энхцэцэг

Хараат бус гишүүн

Ганболдын Сономжамц

ХОЁР. ТУЗ-ийн гишүүнээр улиран сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, Компанийн засаглалын зарчмыг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  С.БАЯНЧУЛУУН





“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.03.30

№ ХЭ2014004

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн чөлөөлж, шинээр томилох тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 3 сарын 30-ны өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэл, Нэр дэвшүүлэх хорооны санал, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.7; Компанийн дүрмийн 7.7.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Отгогжаргал, Х.Төмөрхуяг нарын бүрэн эрхийг өөрсдийнх нь гаргасан саналыг үндэслэн дуусгавар болгож, Хараат бус гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

ХОЁР. Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн Б.Бат-Ирээдүй, Д.Байлхүү нарыг 2014 оны 3 сарын 30-ны өдрөөс эхлэн 2015 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилсугай.

ГУРАВ. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, Компанийн засаглалын зарчмыг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  С.БАЯНЧУЛУУН

